



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 4, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 ширхэг, нийт 83,500,000.00 (наян гурван сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Баярсүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000283

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 6 дүгээр сарын 07-ны өдрийн  
139. дугаар тогтоолын хавсралт



**ХОВД АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР  
ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Хөрөнгийн нэр, дугаар                           | Үйлд-сэн/<br>Ашиглалтад<br>орсон он | Балансын үнэ<br>(төгрөг)              | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)     | Үлдэгдэл<br>өртөг<br>(төгрөг) | Худалдах доод<br>үнэ (төгрөг) |
|-----|-------------------------------------------------|-------------------------------------|---------------------------------------|---------------------------------------|-------------------------------|-------------------------------|
| 1   | Суудлын автомашин<br>Лексус-RX330, ХОУ 46-85    | 2004/2012                           | 35,000,000.00                         | 35,000,000.00                         | -                             | 3,000,000.00                  |
| 1   | Суудлын автомашин Ланд<br>крузер-100, ХОУ 68-55 | 2005/2006                           | 48,500,000.00                         | 48,500,000.00                         | -                             | 3,000,000.00                  |
|     | <b>Нийт дүн</b>                                 |                                     | <b>83,500,000.00</b>                  | <b>83,500,000.00</b>                  | -                             | <b>6,000,000.00</b>           |
|     |                                                 |                                     | (наян гурван сая<br>таван зуун мянга) | (наян гурван сая<br>таван зуун мянга) |                               | (зургаан сая)                 |